



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөний хөтөлбөр”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил, жилээр нарийвчлан төлөвлөн төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлүүлж, хэрэгжүүлэхийг Захиргаа удирдлагын газар (Л.Намхайноров), шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг байгууллагын төсөвт тусгуулан ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Дугармаа) нарт үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийж, зохих арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллахыг Чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан дэд дарга (Д.Уранзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭЦЭГСАЙХАН

142021 01065

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын  
газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 10 -ны  
өдрийн 1/... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

66

## ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР”

### **Нэг: Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт “төрийн байгууллага төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан.

Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасны дагуу төрийн албан хаагч нь ажиллах нөхцөлөөр хангуулах эрхтэй.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь тус байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

### **Хоёр: Хөтөлбөрийн зорилго**

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын зорилт, чиг үүргийг хараат бусаар, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл баталгааг сайжруулахад (хангахад) энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### **Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

- 3.1. Бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх,
- 3.2. Шийдвэр гаргах үйл ажиллагаа ил тод, нээлттэй, албан хаагчдын тэгш оролцоо, шударга байдлыг хангасан байх,
- 3.3. Дотоод нөөц бололцоог дайчлан, хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой зөв хуваарилах,

### **Дөрөв: Хөтөлбөрийн үндсэн зорилт**

- 4.1. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллыг уян хатан, ил тод, шударга тогтоох,
- 4.2. Албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- 4.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх,
- 4.4. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах,

### **Тав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ**

“Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллыг уян хатан, ил тод, шударга тогтоох” үндсэн зорилтын хүрээнд:

- Албан хаагчдын цалин хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ, ур чадвар, мэргэшлийн түвшинд тулгуурлан шинэчлэн тогтоож байх,

-Төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэрэг цолны, ур чадварын нэмэгдэл болон бусад нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу тооцон олгож байх,

-Түр эзгүй албан хаагчийн ажил үүргийг түр орлон ажилласан тохиолдолд ажлын гүйцэтгэл, хугацаа зэргийг харгалзан үндсэн цалингийн зөрүү эсвэл, нэмэгдэл олгох,

-Байгууллагын захиалгаар урт хугацааны сургалтад гэрээ байгуулан хамрагдаж, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу төлж, баталгаажуулах, гэрээнд заасан баталгааг эдлүүлэх,

- Албан хаагчийн ажилласан хугацаа, ажлын үр бүтээл, идэвх санаачилгыг харгалзан төрийн одон медаль, салбарын болон байгууллагын шагнал, мөнгөн болон материаллаг урамшуулал олгох,

“Албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” үндсэн зорилтын хүрээнд:

-Орон сууцаар хангагдах, нөхцлөө сайжруулах талаар гаргасан албан хаагчийн өргөдөл хүсэлтийг бүртгэж, ил тод нээлттэй, шударгаар шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх,

- Албан хаагчдыг орон сууцны урт, богино хугацааны зээлд хамрагдахад нь хуульд заасан дэмжлэг үзүүлэх,

“Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” үндсэн зорилтын хүрээнд:

- Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн хууль, журамд заасан үндэслэлээр хөдөлмөрийн харилцааг өөрчлөх буюу дуусгавар болгох,

- Албан хаагчдыг жил бүр эмнэлгийн урьдчилан сэргийлэх, үзлэг, шинжилгээнд хамруулах,

- Нийтийг хамарсан цар тахал, халдварт өвчин, байгалийн давагдашгүй нөхцөл үүссэн үед албан хаагчдын халдвар хамгаалал, халдваргүйжүүлэлт, дархлаа дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,

- Албан хаагчдыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн амралт, сувиллын газарт сувилуулж эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

- Албан хаагчдыг ээлжийн амралтаа биеэр эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх,

- Албан хаагчдыг ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн болон өдрийн хоолны зардлын зохих хэсгийг нөхөн олгох,

-Гэрт болон галлагаатай байранд амьдардаг албан хаагчид түлээ, нүүрс худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

-Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын дагуу томилолтоор ажилласан, орон нутагт томилогдсон болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр албан хаагчид нөхөн төлбөр олгох,

-Албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан доромжлох, заналхийлэх, гүтгэх, бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчийг хамгаалах арга хэмжээ авах,

- Албан хаагчдыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд дэмжлэг үзүүлэх, уралдаан, тэмцээн, үзвэр, үйлчилгээ, өвөл, зуны аялал, зугаалга зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах,

-Байгууллагын шийдвэрээр богино хугацааны сургалтад хамрагдаж байгаа албан хаагчид суралцах хугацаанд нь цалин хөлсийг бүрэн олгох, урт хугацааны сургалтад хамрагдсан тохиолдолд цалингийн 60%-ийг олгох,

-Албан хаагч шинээр гэр бүл болсон, Төрийн дээд шагнал хүртсэн, эрдмийн зэрэг цол хамгаалсан, гэр бүлийн гишүүн нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж өгөх,

- Албан хаагч хөдөлмөрийн чадвараа 50%-аас дээш алдсан нь тогтоогдсон албан хаагчийн хуульд заасан ажлын цагийг мөрдүүлэх, хэрэв бүтэн цагаар ажиллаж байгаа бол 1 цагийн хөлсийг илүү цагаар ажилласнаар тооцох олгох,

- Хөдөлмөрийн чадвараа алдсан алба хаагчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх,

-Хуульд заасан бусад нийтлэг баталгааг албан хаагчдад эдлүүлэх,

“Ажиллах нөхцөлийг сайжруулах” үндсэн зорилтын хүрээнд:

-Албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын нөхцлийг бүрдүүлж, техник хэрэгсэл (өрөө, тасалгаа, компьютер, хэвлэгч, хувилагч, ширээ, сандал, бичгийн хэрэгсэл, суурин харилцаа, холбооны аппарат гэх мэт)-ээр хангах,

-Ажлын байрны хэвийн нөхцөл (халаалт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, цэвэрлэгээ гэх мэт)-ийг хангах,

-Байгууллагын мэдээллийн технологи, дотоод сүлжээний ашиглалтыг сайжруулах, ажлыг хөнгөвчлөх арга хэмжээг байнга авч ажиллах,

-Албан хаагчдын ажлын чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх, илүү шат дамжлага, давхардлыг арилгах арга хэмжээ авах,

-Албан хаагчдыг шаардлагатай тохиолдолд хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангах,

-Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанг холбогдох хууль, журамд заасны дагуу хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хувцас, бусад хэрэгслэлээр хангах,

-Албан хаагчдыг хөдөө, орон нутагт томилолтоор ажиллуулахад тээврийн хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг ханган, туулах чадвар сайтай автомашинаар үйлчлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар хангах,

### **Зургаа: Хөтөлбөрийн шалгуур**

“Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллыг уян хатан, ил тод, шударга тогтоох” үндсэн зорилтын хүрээнд:

-Албан хаагчдын цалин хөлсийг тэдгээрийн ажлын үр дүн, мэргэжлийн ур чадвартай уялдуулан тогтоодог болсон байна.

“Албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” үндсэн зорилтын хүрээнд:

-Албан хаагчдыг орон сууцаар хангах асуудалд хууль, журмын хүрээнд дэмжлэг үзүүлсэн байна.

“Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” үндсэн зорилтын хүрээнд:

-Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн баталгааг хуулийн хүрээнд хангасан байна.

“Ажиллах нөхцөлийг сайжруулах” үндсэн зорилтын хүрээнд:

-Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр бодитой тодорхой ахиц гаргасан байна.

**Долоо: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, удирдлага, зохион байгуулалт**

Хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2021-2025 онд хэрэгжүүлнэ.

Энэхүү хөтөлбөрийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хангах ажлыг жил бүр нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ.

Захиргаа, удирдлагын газар хэрэгжилтийг хариуцаж, хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын нийт албан хаагчдын идэвхтэй оролцоо, төрийн болон төрийн бус, олон улсын, хандивлагч байгууллагуудын туслалцаа, дэмжлэгт тулгуурлана.

**Найм: Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын төсөв
- Төрийн болон төрийн бус байгууллагын туслалцаа, дэмжлэг
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, буцалтгүй тусламж
- Хамтын ажиллагаатай гадаад, дотоодын байгууллагын туслалцаа, дэмжлэг
- Бусад санхүүжилт

- - - о О о - - -

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын  
газрын даргын 20.21 оны 05 дугаар сарын 10-ны  
өдрийн 1/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт  
66

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР**

**Зорилго:**

Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь байгууллагын боловсон хүчнийг чадавхжуулах зорилтын хүрээнд удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, хувь хүний хөгжил, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, салбарын хууль тогтоомж, эмийн зохицуулалтын систем, эмийн бүтээгдэхүүний зах зээлийн дараах тандалт, судалгаа, олон улсын зохицуулалтын байгууллагуудын сайн туршлагыг нэвтрүүлэхтэй холбоотой суурь мэдлэг олгох зорилгоор сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

**Хамрах хүрээ:**

Байгууллагын нийт албан хаагчид

**Сургалтын хугацаа:**

2021 оны 2-4 дүгээр улирал

**Сургалтын хэлбэр:**

Танхим болон цахим

**Хүлээгдэж буй үр дүн:**

1.Эмийн зохицуулалтын систем, аюулгүй, чанарын баталгаатай, эмчилгээний өндөр идэвхтэй эмээр жигд хангахад эмийн бүтээгдэхүүний зах зээлийн дараах тандалт, судалгаа болон холбогдох хууль эрх зүйн орчин, улс орнуудын сайн туршлага, стандартын талаар нэгдсэн ойлголттой болно.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв зан үйлийг байгууллагын хэмжээнд төлөвшүүлэн, харилцааны ур чадварыг эзэмшсэн байна.

3.Авлигын шалтгаан, нөхцөл, хор уршиг, нийтийн, хувийн ашиг сонирхлын болон аливаа зөрчлийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ойлголттой болсон байна.

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР**

| №  | №    | Сургалтын сэдэв                                                          | Сургалтын хэлбэр | Сургалт хариуцах газар, хамтран ажиллах байгууллага | Сургалт зохион байгуулах хугацаа |
|----|------|--------------------------------------------------------------------------|------------------|-----------------------------------------------------|----------------------------------|
| 1. | 1.1. | Албан хэрэг хөтлөлт                                                      | Цахим            | ЗУГ                                                 | 2021 оны II улирал               |
| 2. | 2.1. | Ковидын вакцины тухай                                                    | Цахим            | ЗУГ<br>Австрали улсын профессор Ким Малхолланд      | 2021 оны II улирал               |
| 3. | 3.1. | Эмийн зохицуулалтын систем, хууль эрх зүйн орчин                         | Танхим           | ЗУГ<br>ДЭМБ                                         | 2021 оны II улирал               |
| 4. | 4.1. | Эмийг зах зээлд гаргах зөвшөөрлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь | Танхим<br>Цахим  | ЭБХ<br>ДЭМБ                                         | 2021 оны III улирал              |
|    | 4.2. | Эмийн бүртгэлийн зохицуулалтын олон улсын жишиг тогтоох үнэлгээ          |                  |                                                     |                                  |
|    | 4.3. | Эмийн бүртгэлийн сайн засаглал, ил тод байдал                            |                  |                                                     |                                  |
|    | 4.4. | Эмийн бүртгэлийн үндсэн зарчим, эрх зүйн орчин                           |                  |                                                     |                                  |
|    | 4.5. | Био-эквивалент чанар                                                     |                  |                                                     |                                  |
|    | 4.6. | Тогтвортой чанарын судалгааны ач холбогдол                               |                  |                                                     |                                  |
|    | 4.7. | Good reliance practice                                                   |                  |                                                     |                                  |
| 5. | 5.1. | Тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг боловсронгуй болгох нь                  | Танхим<br>Цахим  | ЛЗЗГ<br>ДЭМБ<br>АХБ<br>АШУУИС                       | 2021 оны III улирал              |
|    | 5.2. | Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын олон улсын жишиг тогтоох үнэлгээ        |                  |                                                     |                                  |
|    | 5.3. | Тусгай зөвшөөрлийн үндсэн зарчим, эрх зүйн орчин                         |                  |                                                     |                                  |
|    | 5.4. | Сайн засаглал- Тусгай зөвшөөрлийн ил тод байдал                          |                  |                                                     |                                  |

|      |                                                                                                               |                 |                                                            |                     |  |
|------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|------------------------------------------------------------|---------------------|--|
| 5.5. | Тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авахаас шийдвэр гаргах хүртэлх процесс                                       |                 |                                                            |                     |  |
| 5.6. | Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн тусгай зөвшөөрөл, тавигдах шаардага                                       |                 |                                                            |                     |  |
| 6.1. | Зах зээлд эм, вакцины чанар, аюулгүй байдлын тандалтыг хэрэгжүүлэх нь                                         | Танхим<br>Цахим | ЭАБТСГ<br><br>ЭМЯ<br>ДЭМБ<br>АШУУИС<br>ДХИС<br>МХЕГ<br>ЦЕГ | 2021 оны III улирал |  |
| 6.2. | ДЭМБ-ын Хуурамч эмээс сэрэмжлүүлэх систем                                                                     |                 |                                                            |                     |  |
| 6.3. | Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт-Эрх зүйн орчин                                                                |                 |                                                            |                     |  |
| 6.4. | Хуурамч эмийн гадаад нөхцөл байдал                                                                            |                 |                                                            |                     |  |
| 6.5. | Стандартын бус болон хуурамч эмийн ялгаа, тэдгээрийн илрүүлэг                                                 |                 |                                                            |                     |  |
| 6.6. | Эмийн хяналтын лабораторийн өнөөгийн байдал                                                                   |                 |                                                            |                     |  |
| 6.7. | Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн шалтгаант гэмт хэрэг, тэдгээрийн илрүүлэг                                   |                 |                                                            |                     |  |
| 7.1. | Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал                                                                              | Цахим           | ЗУГ<br>“Түгээмэл Хөгжил” ТББ                               | 2021 оны III улирал |  |
| 8.1. | Фармаковижилансыг бэхжүүлэх нь                                                                                | Танхим<br>Цахим | ЭАБТСГ<br><br>ДЭМБ                                         | 2021 оны III улирал |  |
| 8.2. | Фармаковижилансын зохицуулалтын олон улсын жишиг тогтоох үнэлгээ                                              |                 |                                                            |                     |  |
| 8.3. | Фармаковижилансын үндсэн зарчим, Улпсала хяналтын төвийн тухай ойлголт                                        |                 |                                                            |                     |  |
| 8.4. | Эмийн гаж нөлөөний тандалтын зохицуулалтын олон улсын жишиг тогтоох үнэлгээ                                   |                 |                                                            |                     |  |
| 8.5. | Эмийн аюулгүй байдлыг сайжруулахад зохицуулалтын байгууллага ба эм бүртгүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлага |                 |                                                            |                     |  |
| 8.6. | Эмийн зах зээлийн хяналт, чанарын доголдолтой эмийн бүтээгдэхүүний эргүүлэн татах үйл ажиллагаа               |                 |                                                            |                     |  |

|     |       |                                                                                                                                            |                   |                                              |                         |
|-----|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|----------------------------------------------|-------------------------|
| 9.  | 9.1.  | Олон улсын эмийн хөтөлбөрийн тухай                                                                                                         | Цахим             | ЭАБТСГ<br>УППСАЛА хяналтын төв               | 2021 оны III улирал     |
| 10. | 10.1. | Авлига, ашиг сонирхол                                                                                                                      | Цахим,<br>Танхим  | ЗУГ<br>АТГ                                   | 2021 оны II, III улирал |
| 11. | 11.1. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журам, стандарт                                                                      | Цахим             | ЗУГ<br>ХАБЭМТ                                | 2021 оны III улирал     |
| 12. | 12.1. | Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлс, түүнээс урьдчилан сэргийлэх нь                                                                     | Цахим             | ЗУГ<br>ХАБЭМТ                                | 2021 оны III улирал     |
| 13. | 13.1. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай                                                                                             | Танхим            | ЗУГ<br>ЦЕГ                                   | 2021 оны III улирал     |
| 14. | 14.1. | Ажлын байранд аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг үнэлэхэд ажилтны оролцоо                                                                   | Цахим             | ЗУГ<br>ХАБЭМТ                                | 2021 оны IV улирал      |
| 15. | 15.1. | Харилцаа ба хандлага                                                                                                                       | Танхим            | ЗУГ<br>Talent Management                     | 2021 оны IV улирал      |
| 16. | 16.1. | Байгууллагын, нэгжийн, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах талаарх богино хугацааны мэргэшүүлэх сургалт | Танхим            | ЗУГ<br>ЗГХЭГ-ын харьяа<br>Удирдлагын академи | 2021 оны IV улирал      |
| 17. | 17.1. | Албан хэрэг хөтлөлт                                                                                                                        | Цахим             | ЗУГ                                          | 2021 оны IV улирал      |
| 18. | 18.1. | Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт                                                                                                       | Танхим<br>Дадлага | ЗУГ<br>ОБЕГ                                  | 2021 оны IV улирал      |
| 19. | 19.1. | Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын ерөнхий ойлголт                                                                                   | Цахим             | ЭУХ                                          | 2021 оны IV улирал      |